



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1118

Улаанбаатар хот

┌ Тоон гарын үсгийн гэрчилгээ хүсэх ┐
итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Дижитал Монгол хөтөлбөр, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Дижитал Монгол” хөтөлбөрийн хүрээнд цахим хэрэглээг дэмжих, олон улсад бий болоод буй шинэ төрлийн коронавирусын халдварт цар тахлын аюулаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, биечилсэн харилцааг багасгах зорилгоор E-токен төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж эхлэхтэй холбогдуулан тоон гарын үсгийн гэрчилгээ хүсэх итгэмжлэгдсэн ажилтнаар Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Миеэгомбын Мөнхдуламыг томилсугай.

2. Тоон гарын үсгийн гэрчилгээ хүсэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг М.Мөнхдуламд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны Ахлах мэргэжилтэн /Б.Номинзул/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН